

БНХАУ-ЫН ШАШНЫ ТАЛААР АВЧ ЯВУУЛЖ БҮЙ БОДЛОГО

Д. Ундрас (Ph.D)

Ази судлалын тэнхим
ШУС. МУИС

Түлхүүр үг: БНХАУ, Шашин, хууль зүйн тогтолцоо, шашин шүтэх эрх чөлөө, буддын шашин.

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд БНХАУ дахь шашны тархалт, шашны байгууллагуудын үйл ажиллагаа, шашны тухай тусгасан хууль зүйн тогтолцоог танилцуулан, Хятадын хуулийн шашны эрх чөлөө, шашныг зохицуулах онцлог шинжид дүгнэлт хийж тэдний хэрхэн үйл ажиллагаагаа явуулах талаар асуудал дэвшиүүллээ. Хоёрдугаар хэсэгт шашны эрх чөлөөтэй холбоотой хятадын хууль зүйн тогтолцоо, “Төвдийн уламжлалт буддын шашны цол мяндаг авах арга”-ын онцлог шинжийг, гуравдугаар хэсэгт мөн түүнтэй холбогдох бусад хууль журам, түүний онцлог шинжийг, дөрөөвдүгээр хэсэгт эцсийн дүгнэлтийг тус тус тусгалаа.

* * * *

1. Хууль зүйн тогтолцоо, нөхцөл байдал

Хятадад олон шашин зэрэгцэн оршсоор даруй хэдэн зууныг өнгөрөөжээ. Одоогийн байдлаар Буддын шашин (Тхеревада болон Махаяана), Бомбын шашин, Ислам, Католик, Протестант гэсэн 5 гол шашин байна. Буддын шашин Бомбын шашны сүсэгтнүүд зонхилох хувийг эзэлдэг байна. Гэвч шашинд итгэгчдийн тоог нарийн тодорхой гаргаагүй байгаа ажээ. Буддын шашны ажилтан /лам/ 222000, Бомбын шашны ажилтан 40000, Исламын шашны байгууллагын ажилтан 57000 гаруй хүн, Католик шашны итгэгч 600 0000 хүн, шашны байгууллагад нь ажиллаж буй 8000 гаруй хүн, Протестант шашны итгэгч 3 800 000 хүн, шашны байгууллагад нь 57000 хүн тус тус ажиллаж байна.¹ Хятадад ойролцоогоор 5500 шашны бүлгэм байх бөгөөд бүх улсыг хамарсан 7 бүлгэм байдаг. Үүнд: Хятадын Буддын шашны нийгэмлэг, Хятадын Бомбын шашны нийгэмлэг, Хятадын Исламын шашны нийгэмлэг, Хятадын Католик шашны эх орончдын хурал, Хятадын Католик шашны номлогчдын бүлгэм, Хятадын Протестант шашны гурван чөлөөт эх орончдын хөдөлгөөний гишүүдийн хурал, Хятадын Протестант шашны нийгэмлэг орно.²

¹ <http://www.sara.gov.cn/xwfb/xwjj/20170905093618359691/581898.htm>

² <http://www.sara.gov.cn/xwfb/xwjj/20170905093618359691/581898.htm>

Хятад улсын хэмжээнд хууль журмын дагуу үйл ажиллагаа явуулж бүртгүүлсэн, хуулиар хамгаалуулсан 33500 Буддын сүм хийд, түүний дотор Хятадын уламжлалт буддын шашны сүм хийд 28000, Төвдийн уламжлалт буддын сүм хийд 3800, Өмнөдийн уламжлалт буддын шашны сүм хийд 1700, Бомбын шашны сүм 9000 гаруй, Исламын ариун сүм 35000 гаруй, Католик шашны сүмийн бүс 98, мөргөлийн сүм болон цуглааны газар 6000, Протестант шашны мөргөлийн сүм болон чуулган 60000 байна. Шашны эрх чөлөөг хамгаалах Хятадын хууль зүйн тогтолцоо гэдэгт БХАТИХ, тэдний төлөөлөгчдийн тунхагласан хууль тогтоомж, Төрийн Зөвлөлөөс тунхагласан засаг захиргааны журам зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилт, хяналт зэрэг ойлголтууд багтана.

Хамгийн гол тулгуур хууль нь 2004 онд шинэчлэн батлагдсан БНХАУ-ын Үндсэн Хууль бөгөөд энд өөр өөр шашин шүтдэг хүмүүс нь санал өгөх тэгш эрхтэй³, шашны эрх чөлөөг эдлэх эрхтэй⁴ гэж заасан байна. Үндсэн хуулийн 36 дугаар зүйлд:

БНХАУ-ын иргэн бүр шашны эрх чөлөөг эдэлнэ.

Аливаа төрийн буюу олон нийтийн байгууллага нь иргэнийг ямарваа нэгэн шашинд итгэх, үл итгэхийг албадан шаардахгүй, аль нэгэн шашин шүтдэгээр нь ялгаварлан гадуурхахгүй.

Төр нь шашны тайван хөдөлгөөнийг хамгаална. Шашны нэрийг барьж олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулах, төрийн боловсролын системд саад болох аливаа үйл ажиллагаа явуулж үл болно.

Шашны зүтгэлтэн, шашны үйл ажиллагаагаар дамжуулан гадны ноёрхлыг тогтоож үл болно” гэжээ.

Үндсэн Хуулиас гадна 2001 онд батлагдсан “БНХАУ-ын Бүс Нутгийн, Үндэсний өөртөө засах орны хууль”, 1986 онд батлагдсан “Иргэний хуулийн Ерөнхий Журмууд”, “Боловсролын тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Зайлшгүй эзэмших боловсролын тухай хууль”, “БНХАУ-ын Орон нутгийн оршин суух зөвлөлийн хууль”, “Зар сурталчилгааны тухай хууль” зэрэгт шашны зүтгэлтнүүдийн эд хөрөнгийг хамгаалах тухай, шашин болон боловсрол нь тусдаа ойлголт болох тухай, өөр өөр шашин шүтдэг иргэд нь адил тэгш боловсрол эзэмших эрхтэй тухай, шашны янз бүрийн соёл, зан заншлыг хүндэтгэх тухай, бүх иргэд хөдөлмөр эрхлэх тэгш эрхтэй тухай, мөн аливаа нэгэн зар сурталчилгаанд аль нэгэн шашныг гадуурхаж үл болох тухай заасан байдаг.

“Шашны хэрэг зохицуулах хэлтэс”-ээс санаачлан доорхи дүрэм журмуудыг Төрийн Зөвлөлөөр батлуулж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

³ Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлд: “БНХАУ-ын 18 насанд хүрсэн иргэн бүр үндэстэн, арьс өнгө, хүйс, мэргэжил, нийгмийн гарал, итгэл үнэмшил, боловсрол, эд хөрөнгө үл харгалzan сонгуульд санал өгөх эрхтэй ” гэж заажээ.

⁴ Үндсэн хуулийн 36 дугаар зүйл.

2000 онд “БНХАУ-ын нутаг дэвсгэр дээрхи гадаадын иргэдийн шашны үйл ажиллагааны хяналт, заалт, хэрэгжилтийн дүрэм” БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс баталж 2010 онд шинэчлэн засварлажээ.

Эдгээрээс хамгийн чухал харилцааг зохицуулдаг “Шашны хэрэг эрхлэх тухай хууль” 2004 оны 11 дүгээр сарын 30 өдөр БНХАУ-ын Төрийн зөвлөлийн 426 дугаар тогтоолоор батлагдаж, 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Төрийн зөвлөлийн 1176 дахь удаагийн хуралдаанаар шинэчлэн засварлагдсан байдаг.

2005 онд “Шашны үйл ажиллагааны зохицуулалт” БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс баталсан байна.

2012 онд “Шашны сургуульд зэрэг авах аргачлал”, “Шашны сургуулийн багшийн эрхийг баталгаажуулах хийгээд цол тушаалыг хянах аргачлал”, 2015 онд “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал”, 2018 онд “БНХАУ-ын шашны хэрэг зохицуулах хэлтсээс сургаал номлол айлдсаны төлбөрийг хянах арга” гэх журмуудыг баталсан байна.

2018 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс баталсан “Шашин шүтэх эрх чөлөөг хамгаалах Хятадын төрийн бодлого хийгээд биелэлт” хэмээх хуулийг 2018 оны 4 дүгээр сарын 3 ны өдөр “Цагаан хавтаст ном” болгон нийтэлсэн байна.

Энэхүү “Цагаан хавтаст ном” нь 8000 үсэгтэй бөгөөд өмнөх үг, дүгнэлтээс гадна нийт шашин шүтэх эрх чөлөөг хамгаалах үндсэн бодлого, шашин шүтэх эрх чөлөөний бүрэн эрхийн хуулиар хамгаалах, шашны арга хэмжээг дэс дараалалтай явуулах, шашны хүрээллийн үйл явдлын ололтыг бүрэн дүүрэн дэлгэрүүлэх, шашны харилцааг идэвхийлэн эрүүлжүүлэх гэсэн гарчигтай тус тус 5 бүлгээс бүрднэ.

Эдгээр дүрэм журмуудыг баталж гаргах явцад “Шашны хэрэг зохицуулах хэлтэс”-ээс шашны зохицуулалттай холбоотой нийт 44 баримт бичгийг 1982 оны 8 дугаар сарын 14 нөөс 2016 оны 5 дугаар сарын хооронд, шашны тухай хориглох зүйлүүдийн тухай нийт 10 бичиг баримтыг 1987 оны 7 сарын 9-нөөс 2014 оны 8 сарын 14 хүртэл тус тус гарган баталж хэрэгжүүлж ирсэн байна.⁵

Шашны бүлэглэл хийгээд хөдөлгөөнийг нэгдсэн нэг хуулиар зохицуулж тэдний үйл ажиллагаагаа явуулах таатай боломж олгох үүднээс ус, цахилгаан, ахуйн шингэн хий, дулаан, зам, харилцаа, зэрэгт нь хөнгөлөлт үзүүлж олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, эмнэлэгийн үйлчилгээ зэрэг нийтийн үйлчилгээг ялгалгүй үзүүлэх заалтыг дээр дурьдсан хуулинд оруулж өгсөн байна.⁶ Харин шашны зүтгэлтэн, ялангуяа гадаадын шашны зүтгэлтэнд зориулсан доорхи тусгайлсан 2 журам байдаг байна.⁷ Энэ тухай хойно өгүүлнэ.

⁵ <http://www.sara.gov.cn/zcfg/jg/xj/573641.htm>

⁶ <http://www.sara.gov.cn/xwfb/index.htm>

⁷ <http://www.sara.gov.cn/xwfb/index.htm/381.htm>

2. “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” журмын тухай

Энэ журам 2015 оны 4 дүгээр сарын 16 ны өдөр нийт таван бүлэг хорин таван зүйлтэйгээр батлагдаж 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байдаг.

Ерөнхий зүйлд зааснаар төвдийн уламжлалт буддын шашны зэрэг олгох ажлыг журамлах, төвдийн уламжлалт шашны боловсон хүчнийг бэлтгэх ажлыг урагшуулахын тулд “Шашны сургуулиудад зэрэг олгох тухай арга” зэрэг Хятад улсын холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, төвдийн уламжлалт буддын шашны практикийг хослуулан энэхүү аргачлалыг тогтоосон⁸ ба шашны дээд сургууль⁹, шашны зэрэг цол авч болох хүмүүсийн шаардлага¹⁰, зэрэг цол олгох эрх бүхий байгууллага¹¹, зэрэг цолыг олгохыг хянах байгууллагын тухай¹² тус тус нарийвчлан заажээ .

Тус журмын 2 дугаар бүлэг нь зэрэг цолны зэрэглэл болон үнэлгээний байгууллагыг хэрхэн байгуулахтай холбоотой нийт таван зүйлээс бүрдجээ. Энэ бүлэгт зааснаар төвдийн уламжлалт буддын шашны академик зэрэг нь гурван

⁸ “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал”/2015/ 1 дүгээр зүйл: төвдийн уламжлалт буддын шашны зэрэг олгох ажлыг журамлах, төвдийн уламжлалт шашны боловсон хүчнийг бэлтгэх ажлыг урагшуулахын тулд “Шашны сургуулиудад зэрэг олгох тухай арга” зэрэг Хятад улсын холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, төвдийн уламжлалт буддын шашны практикийг хослуулан энэхүү аргачлалыг тогтоов.

⁹ “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” 2 дугаар зүйл: Энэхүү аргад нэрлэгдэн буй төвдийн уламжлалт буддын шашны сургууль гэдэг нь “Шашны хэрэг эрхлэх тухай хууль”, “Шашны сургууль байгуулах арга” зэрэг бичиг баримтуудад заасан, Хятадын буддын шашны нийгэмлэг эсвэл муж, өөртөө засах орны буддын шашны булгэмдлээс байгуулсан, төвдийн уламжлалт буддын шашны ажилтан хийгээд мэргэжлийн ажилтныг өдөр тутам сурган бойжсуулж байдал дээд сургуулийг хэлнэ.

¹⁰ “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” 3 дугаар зүйл: Энэхүү замд заасан төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол гэдэг нь төвдийн уламжлалт буддын шашны сургуулийн суралцагч нь суралцах хугацаагаа дуусгаж, сурлагын дун нь тэнцсэн эсвэл сүм хийдээд шавилсан суралцагч дээр дурьдсантай адилтгах хүч чармайлт гаргасан ба төвдийн уламжлалт буддын шашны сургуулийн академик зэрэг олгох шүүгчдийн зөвлөлөөс улс төрийн узлийг нь илэрхийсэн, шашны ариун журамтай, хичээлийн шалгалт, дагсал, диссертацийн хамгаалалт зэрэг нөхцөл байдалд олон талын шалгалтанд тэнцсэний дараа хүртэх зэрэг цолыг хэлнэ.

¹¹ “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” 4 дүгээр зүйл: Хятадын буддын шашны нийгэмлэг нь төвдийн уламжлалт буддын шашны академик зэрэг олгох ажлын удирдах зөвлөлийг болон төвдийн уламжлалт буддын шашны зэрэг олгохтой холбогдсон бүхий л ажлыг хариуцна. Төвдийн уламжлалт шашны академик зэрэг олгох ажлын удирдах зөвлөлийн гишүүнийг Хятадын буддын шашны нийгэмлэгээс сонгож ба Хятад улсын шашны хэрэг эрхлэх газарт мэдэгдэж бичиг баримтад тэмдэглүүлсний дараа, Хятадын буддын шашны зөвлөлөөс гишүүний үнэмлэхийг олгоно. Төвдийн уламжлалт буддын шашны академик зэрэг олгох ажлын удирдах зөвлөлийн гишүүний өдөр тутмын ажлыг Хятадын түвшдээ хэлтэй өндөр зэрэглэлийн буддын шашны сургууль хариуцна.

¹² “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” 5 дугаар зүйл: Хятад улсын шашны хэрэг эрхлэх газар болон муж, өөртөө засах орны ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэс нь төвдийн уламжлалт буддын шашны академик зэрэг олгох ажилд хяналт тавина.

зэрэглэлтэй байх ба энэ нь Цаньриба, Жюранба, Тууринба болно гэж заажээ.¹³ Дээр дурьдсан зэрэглэлийн Цаньринба, Жюранба зэргийг муж өөртөө засах орны буддын шашны бүлгэмээс байгуулсан зөвлөл хийгээд төвдийн уламжлалт буддын шашны дээд сургуулиас хүртээнэ. Тууринба зэргийг Хятадын түвд хэлт дээд зэрэглэлийн буддын сургуулиас хүртээнэ хэмээн заажээ. Мөн түүнчлэн үнэлгээг хэрхэн хийх, зэргийн үнэмлэх диплом хэрхэн олгох процессыг нарийвчилжээ. Гуравдугаар бүлгийн таван зүйлд зэрэг авахаар өргөдөл гаргагчид тавигдах шаардлагыг тодорхой заасны дотор чойрын сургалтанд заавал үзэж дүүргэсэн байх номуудыг тодорхой заажээ.¹⁴ Тус журмын дөрөвдүгээр бүлэгт академик зэрэг авах өргөдөл гаргах олгох тухай зургаан зүйл, тавдугаар бүлэгт хориглох зүйл багтжээ.

Дээрх журмаас үзэхэд буддын шашны лам нарын дотроос төвдийн уламжлалт буддын шашин буюу “их хөлгөн”-ий урсгалын лам хуврагуудын зэрэг цол авах хийгээд суралцах ёстой хичээлүүдэд нь төрөөс ямарваа нэгэн хяналт тавьж ялангуяа улс төрийн үзлийн хувьд зөрчилгүй үзэлтэй байх шаардлагыг заавал тавьж байдаг нь харагдаж байна¹⁵. Өөрөөр хэлбэл төр нь шашны дотоод журмаараа зохицуулагдаж ирсэн практик уламжлалд шууд оролцож хяналт тавьдаг ажээ.

3. Хятадын шашны эрх чөлөөг зохицуулах хууль дүрмийн онцлог шинж

A. Шашин, шашны зүтгэлтнүүдийн эрх чөлөөний тухайд

Хятадын шашны эрх чөлөөг хамгаалах тухай хуулийн нэг гол онцлог шинж нь хяналтын шинжтэй (administrative) байдаг.

Нэгдүгээрт, шашны эрх чөлөө гэсэн нэрийн дор олон нийтийн дэг журмыг алдагдуулж болохгүй¹⁶ гэсэн заалт нь Хятадын засгийн газрын шашны хуулийн чухал агуулга болно. Үүний хамгийн гол учир нь 19 дугаар зуунд гадаадуудад мөлжүүлсэн түүхтэй тул тус улсын засгийн газар шашны үйл ажиллагаагаар дамжин гадны ноёрхол тогтох вий хэмээн ихэд болгоомжилдог.

Хоёрдугаарт, Хятадын засгийн газраас шашны байгууллагын байгууллагдсан тухай, шинэчлэлт хийсэн тухай, татан буугдсан тухай бүртгэлийг хянадаг. Шашны үйл ажиллагааны зохицуулалтад заасны дагуу шашны ямар нэгэн байгууллага нь холбоо гэж явах бөгөөд Холбооны бүртгэл хариуцсан байгууллагын доор зохицуулагдах субъект болно¹⁷. Ихэнхдээ Иргэний Хэргийн Яам болон орон нутгийн иргэний хэрэг хариуцсан эрх мэдэлтэн эдгээр бүртгэлийг хариуцдаг¹⁸. Ямарваа нэгэн шашны боловсролын байгууллага анхлан байгуулагдах бол эхлээд

¹³ “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” 6 дугаар зүйл

¹⁴ “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” 11-15 дугаар зүйл

¹⁵ “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал” 11-15 дугаар зүйл

¹⁶ Үндсэн хуулийн 36 дугаар зүйл, 4 дүгээр хэсэг

¹⁷ Шашны хэргийн журмын б дугаар зүйл

¹⁸ Холбооны бүртгэл хяналтын журмын б дугаар зүйл

Төрийн Зөвлөлийн шашны хэргийн хэлтэс, Иргэний Засгийн мужийн шашны хэрэг эрхэлсэн хэлтэст өргөдөл мэдүүлнэ.

Гуравдугаарт, шашны үйл ажиллагаа явуулах газар, байрлалыг Хятадын Засгийн газраас хянана. Ямар ч сүм, хийд, хүрээ, гандангийн барилга нь баригдаж эхлэхээсээ өмнө, бүр бэлтгэл шатандаа мужийн засгийн газраас зөвшөөрөл авсан байх ёстой¹⁹. Шашны хэргийн хэлтэс нь тус талбайд явагдах аливаа үйл ажиллагаа нь БНХАУ-ын дүрэм журам, зохицуулалтад нийцэж буй эсэх талаар хяналт тавих эрхтэй.

Дөрөвдүгээрт, шашны зүтгэлтэн нэг бүрийг Хятадын Засгийн газраас хянадаг. Зохицуулалтад заасны дагуу ямарваа нэгэн шашны зүтгэлтэн шашны ажлаар, эсвэл хувийн журмаар харьялагддаг байгууллага, газар орноо түр буюу бүр орхин явах бол шашны хэргийн хэлтэст мэдэгдэнэ.

Шашны байгууллагыг хуулийн этгээдээр бүртгэн авах, шашны үйл ажиллагаа явуулахаар барилга барих, шашны тодорхой нэгэн зүтгэлтэн томилолтоор явах, албанаасаа буух зэрэг үед уг үйл ажиллагаа нь хуульд нийцэж буй эсэхийг магадлахаар засгийн газраас хянаж, удирдаж байдаг ажээ.

Б. Шашны эрх чөлөө ба гадныхны үйл ажиллагааны тухайд

БНХАУ байгуулагдсаны дараа засгийн газар гадны олон шашны зүтгэлтэн болоод шашны эрх чөлөөг хянаж эхэлсэн байдаг.

2000 онд Шашны хэргийг зохицуулах төрийн захиргаанаас гаргасан БНХАУ-ын нутаг дэвсгэр дээрхи гадаадын шашны үйл ажиллагааны хяналт, заалт, хэрэгжилтийн дүрэмд ийнхүү заасан байна. Үүнд:

Гадаадын шашны зүтгэлтэн нь зөвхөн муж, өөртөө засах орон, төвд шууд харьялагдах хотын Засгийн газруудад буюу түүнээс дээд шатанд зөвшөөрөгдсөн Хятад шашны зүтгэлтний урилгаар хүрэлцэн ирж хуулиар бүртгэгдсэн газар, талбайд номлол үйлдэхийг зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл Хятадад шашны үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлзэгч ямар ч гадны иргэн Хятад шашны зүтгэлтэнтэй эхлээд холбоо тогтоосон байх шаардлагатай.

Мөн шашны зүтгэлтэн нь нэг хүнд зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хэвлэмэл, эсвэл аудио, видео хэрэглэгдэхүүн авчрах буюу БНХАУ-ын нутаг дэвсгэрт нэвтрүүлэх хориотой. Тус хэрэглэхүүний агуулга нь Хятадын үндэсний аюулгүй байдал, нийгмийн ашиг сонирхолтой зөрчилдөж байвал мөн нэвтрүүлэхийг зөвшөөрөхгүй. Ингэснээр гадны иргэд БНХАУ-ын газар нутагт дураараа товхимол, танилцуулга тараах боломжийг хязгаарлана.

Хятад хүн шашны зүтгэлтнээр суралцахаар гадагш явах, эсвэл гадны иргэнийг Хятадад сургахаар урих бол Шашны хэргийг зохицуулах төрийн захиргаанд бүртгүүлэх ёстой.

¹⁹ Шашины хэргийн журмын 13 дугаар зүйл

Гадны номлогчид дараах зүйлсийг хориглодог.

Үүнд:

1. Хятадын иргэнийг шашны зүтгэлтнээр томилох,
2. Хятадын иргэнийг итгэгчээр элсүүлж авах,
3. Зөвшөөрөлгүйгээр шашны судар номлох, тайлбарлах,
4. Хуулиар бүртгэлгүй газар шашны үйл ажиллагаа явуулах, номлол үйлдэх,
5. Зөвхөн Хятад шашны зүтгэлтнийг орохыг зөвшөөрсөн газар номлол үйлдэх, шашны үйл ажиллагаа явуулах,
6. Шашны холбогдолтой ном, сэтгүүл, аудио видео, электроник бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах,
7. Шашны хэрэглэгдэхүүн тараах,
8. Бусад шашны үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг болно.

Нэгтгэн дүгнэхэд, гадны иргэдийн шашны үйл ажиллагааг зохицуулах тухай Хятадын хууль нь илүү хяналтын шинжтэй болох нь харагдаж байна.

Дүгнэлт

Өнөөдөр БНХАУ-д үнэн сүсэг бишрэлтнүүдийн тоо хурдацтай нэмэгдэж байна. Үүний хэрээр аливаа шашны үйл ажиллагааг ойроос хянах зохицуулах эрмэлзэлтэй Хятадын Засгийн газраас илүү чармайлт гаргаж байгаа билээ. Хятад сүсэг бишрэлтнүүд дэлхий даяар тархсан том шашнуудын үнэнч сүсэгтнүүд учир гадны орны сүсэгтнүүдтэй холбоо тогтоох нь ихсэж буйн хэрээр Хятадын Засгийн газар болоод аливаа шашны байгууллагууд энэ харилцааг нарийвчлан хянаж байдаг байна. Энэ нь Хятад улс өргөн уудам газар нутагтай, олон хүн амтай хийгээд түүхийнхээ урт удаан хугацааны туршид төвлөрсөн систем дээр тулгуурласан засаглалтай байж ирсэний хувьд хууль, засаг захирагааны зохион байгуулалтад тус шинж нь хадгалагдан үлдсэнтэй холбоотой. Нийгмийг эмх цэгтэй байлгахад шаардлагатай шат шатны хяналтыг хэвээр явуулахын тулд боловсруулагдсан хууль зүйн тогтолцоонд ямар нэгэн дарангуйлагч шинж оршиж байна.

Шашны эрх чөлөөтэй холбоотой Хятадын улсын хууль зүйн тогтолцооны онцлог шинжээс харахад гадны орны ямар нэгэн шашны байгууллага Хятадын шашны байгууллага болон сүсэгтнүүдтэй холбоо тогтоохыг хүсвэл эхлээд Хятадын засгийн газартай холбогдох хэрэгтэй. Хятад улс нь төвлөрсөн системтэй тул тус оронд шашныг дэлгэрүүлэхийг эрмэлзэгч нь Засгийн газрын дээд түвшний албан тушаалтан\байгууллагад хүсэлт гаргах хэрэгтэй болдог.

Дашрамд хэлэхэд, манай улсын иргэд БНХАУ-д хэрэгждэг хууль журам тогтоомжийг сайн судлаагүйгээс, холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр шашны үйл ажиллагаа явуулж байгаад цагдаад баригдсан тохиолдол цөөн бус байдаг. Тиймээс гадны шашны байгууллага Хятадад үйл ажиллагаа явуулахаасаа

өмнө хамтран ажиллах Хятадын шашны байгууллага олж хамтарч ажиллавал эрсдэл бага байна гэж үзэж байна..

Ашигласан материал:

1. “БНХАУ-ын үндсэн хууль” / 2004/ шинэчлэн баталсан
2. “БНХАУ-ын нутаг дэвсгэр дээрхи гадаадын иргэдийн шашны үйл ажиллагааны хяналт, заалт, хэрэгжилтийн дүрэм” /2010/ шинэчлэн засварласан
3. “Шашны хэрэг эрхлэх тухай хууль” /2004 оны 11 дүгээр сарын 30 өдөр БНХАУ-ын Төрийн зөвлөлийн 426 дугаар тогтоолоор батлагдаж, 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Төрийн зөвлөлийн 176 дахь удаагийн хуралдаанаар шинэчлэн засварлагдсан/
4. “Шашны үйл ажиллагааны зохицуулалт” /2005/ БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс баталсан байна.
5. “Шашны сургуульд зэрэг авах аргачлал” /2012/
6. “Шашны сургуулийн багшийн эрхийг баталгаажуулах хийгээд цол тушаалыг хянах аргачлал” /2012/
7. “Төвдийн уламжлалт буддын шашны зэрэг цол олгох аргачлал”/ 2015/
8. “БНХАУ-ын шашны хэрэг зохицуулах хэлтэсээс сургаал номлол айлдсаны төлбөрийг хянах арга” /2018/ гэх журмуудыг баталсан байна.
9. “Цагаан хавтаст ном” /2018/
10. <http://www.sara.gov.cn>

ABSTRACT

This article gives a review to religion and religious institutions in China, religious affairs, and related legislation giving a suggestive view of the characteristics of China's approach to religious freedom and religious affairs. Part two reflects the specifics of the Chinese legislation for religion and "Merits of rank ascension in the traditional Tibetan Buddhism", the third part gives further insight to other relevant laws and regulations, and the final part gives conclusions.